

ХҮННҮГИЙН УГСАА ГАРЛЫН ТУХАЙ ХЯТАД ДАХЬ
АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

ЛИНЬ ЮНЬ

(Энэ өгүүлэл нь 林沅学术文集, 北京: 中国大百科全书出版社, 1998, 368-386-р талд хэвлэгдсэн бөгөөд зохиогчийн зөвшөөрөлтэйгээр орчуулан хэвлэв.)

1. Судалгааны удиртгал

“Түүхийн тэмдэглэл” (史记) дэх “Хүннүгийн шастир” (匈奴列传) бол Хүннүгийн (匈奴) эрт үеийн байдлыг улируулан өгүүлсэн үндсэн сурвалж тул хүннүгийн угсаа гарвалыг судлахад Сыма Цяний (司马迁) үзэл бодол маш их нөлөөлдөг.

Сыма Цянь, Хүннүгийн их аймгийн холбоог Мао-дунь (冒顿) үүсгэн байгуулсан тухай өгүүлэхдээ “Дунхуг (东胡) ихээр ялж сөнөөв”, “Өмнөдөд Лоуфань (楼烦), Байян (白羊), Хэнань (河南) ванг дагуулав” зэргээр өгүүлсэн нь тэрбээр Дунху, Лоуфань ба язгуур Хүннү нар хоорондоо өөр гэдгийг тодорхой ухамсарлаж байсныг харуулна. Гэвч тэр язгуур хүннүгийн талаар хомсхон мэдлэгтэй байсан ба зөвхөн “Чуньвэйгээс (淳维) Түмэн (头曼) хүртэл мянга гаруй он өнгөрсөн. Цагийн уртад мандаж, буурч, сарниж хагацалгүй ирэв. Түүний залгамжлалыг үе улируулан үгүүлж эс чадмой” гэж бичжээ. Иймд Цинь (秦) улсаас өмнөх үеийн түүх, судруудаас мэдэгдэж буй умардын үндэстнүүдийг нэг бүрчлэн дурьдаж, тэднийг бүгдийг Хань (汉) улсын үеийн Хүннүгийн үүсвэрт хамруулжээ. Энэ төрлийн Цинь улсын урьдах үеийн умардын үндэстнүүдийн нэгдмэл байдал болоод Хүннүгийн өвөг дээдсийн талаарх үзэл бодол бол Хань улсын үед ганц Сыма Цяний ганцаар баримталж байсан баримтлал биш юм. Жишээлбэл, Хань улсын У-ди (武帝) хаан Хуо Цюбинд (霍去病) өгсөн зарлигийн бичгийн дотор Хүннүг “хүн-юнь (荤允)” гэж нэрлэсэн (“Түүхийн тэмдэглэлийн Вэй жанжин, Пяоцигийн намтар” (卫将军弼骑列传)) болон “Хань улсын судрын Вэй Цин, Хоу Цюбины намтар” (汉书, 卫青霍去病传)), мөн түүхэн дэх Сүн-ю (荤粥) (“Мэнз” Сүн-ю (獯鬻) гэж бичсэн), Сянь-юнь (猃狁) (Баруун Жоугийн хүрэл бичээст Янь-юнь (严允) болон Сюн-нү (匈奴) зэргийг дурдаж болно.

Эдгээр үзэл бодлууд хэлбэршин тогтсон үндсэн хоёр урьдач нөхцөл бий: 1-рт, хүннү аймгийн холбоо олон тооны бие даасан тусгай угсаатны бүлгүүдийг нэгтгэсэн. Тухайлбал, Лоуфань, Байян, Хэнань ванг Хүннүд нэгтгэсний хойно

“Хүннүгийн Хэнань, Байян, Лоуфань ван” хэмээн нэрлэсэн (Түүхийн тэмдэглэлийн Лю жин Шү Суньтунгийн намтар). Хань улсынхны хувьд, Лоуфань бол энэ үеэс эхлэн Хүннүгийн нэг хэсэг юм бол Байлдаант улсын үеийн Лоуфангийг Хань улсын үеийн Хүннүгийн өмнөх үүсгэл гэж харах нь мэдээжийн хэрэг юм. Хоёрдугаарт, умардын үндэстнүүдийн талаарх тухайн үеийн Хань улсын ойлголт харьцангуй мөхөсхөн, умардын нутаг бол асар урт хугацааны турш оршин байсан ба тариачин ард түмнээс огт өөр ертөнц юм, тэндхийн хүмүүс бол “мал адгуулан нүүдэллэдэг, тэдний малын ихэнх нь морь, үхэр, хонь”, “мал маллахын хамт нум сумаар амьтан авлаж амьжиргаандаа нэмэрлэдэг”, “бүгд малын мах идэж, түүний арьсыг өмсдөг”, “хүмүүс нь цэргийн эрдэм ба уулгалан довтлохдоо сурмаг” (Түүхийн тэмдэглэлийн “Хүннүгийн шастир”) зэрэг маш олон нийтлэг шинжтэй учраас эдгээр ард түмнүүдийг нэгэн том угсаатны бүлэгт багтаан үзэх зэргээр тэдний мэдлэг хязгаарлагдаж байв.

Түрүү Цинь улсын үе дэх умардын олон угсаатны нэгдмэл байдлын тухай энэ төрлийн үзэл бодол “Хүннүгийн шастирын” системтэй өгүүлэмжээр дамжин урт хугацаанд өргөн тархжээ. Хань улсын дараах үеийн сурвалж бичгүүдэд умардын янз бүрийн үндэстнүүдийн нэрийн дуудлагад хийсэн тайлбарууд хэдийгээр хоорондоо харилцан адилгүй боловч бүгд энэ төрлийн үзэл бодолд суурилж хөгжжээ. Орчин үеийн эрдэмтдийн үе болоход тухайлбал Ван Гуо-вэйгийн “Гуйфан, кунь-и, сянь-юний шинжилгээ”-нд хийсэн дүгнэлт нь мөн л “Шан, Жоугийн үеэр гуйфан (鬼方), кунь-и (昆夷), сюнь-ю (獯鬻) хэмээн дуудна. Зунжоугийн улиралд болбоос Сянь-юнь (豮豸) хэмээн дуудна. Хавар намрын улсын дараа хүмүүс Сю (戌) ба Ди (狄) хэмээн дуудаж эхлэв. Байлдаант улсын үеэс ху, хүннү хэмээн нэрлэж эхэлсэн” хэмээсэн байдаг.

Угсаатны нэршлийн үүсэл, гарлын асуудлыг “Хүннүгийн шастир” лугаа харьцуулснаараа төдийгүй, нийтдээ эдгээр үзлүүд нэгэн адил юм. Хятадад орчин цагийн түүхийн шинжлэх ухаан хөгжсөнөөс хойш цөөнгүй судлаач өнөөгийн угсаатны зүйн үзэлд үндэслэн Цинь улсын өмнөх үеийн умардын угсаатнуудуудын угсаа хамаарлыг судлах, улмаар хүннүгийн угсаа гарлыг шинээр авч үзэхийг хичээж байна. Гэвч эхэндээ гагцхүү хуучны сурвалжууд доторх хоорондоо адил төстэй, хомс мөчид тэмдэглэл болон ээдрээтэй тайлбаруудыг л судлах боломжтой байв. Учир иймээс угсаатны нэршил, тайлбаруудыг ханз үсгийн утга, дуудлагын ангилал, харьцуулалтын талаас судлах нь үндсэн аргачлал болж байв.

Археологичдын уйгагүй эрэл хайгуулын үр дүнд одоо үед Цинь улсын өмнөх ба Хань улсын үеийн умардын угсаатнуудад холбогдох археологийн судалгааны эх хэрэглэгдэхүүнүүд хуримтлагдаж, бичгийн дурсгалд үлдэж хоцордоггүй соёлын онцлог болон бодит шинж төрхийг илрүүлэн гаргаж байна. Энэ маягаар бид Сыма Цяний үзэл үнэн бодит суурьтай эсэхийг нягтлах боломжтой боллоо. Археологичдын хувьд Сыма Цяний хүннүгийн угсаа гарлын талаарх үзлийг заавал баримтлана гэхгүй нь мэдээж хэрэг юм. Харин Хань улсын үе дэх Хүннүгийн аймгийн холбооны эрхшээж байсан өргөн уудам нутаг дэвсгэр дээр түрүү үеэс үлдэж хоцорсон соёлын ба хүн судлалын нийтлэг байсан эсэхийг анхааралтай шинжилж, эсбөгөөс адил бус тогтолцоонуудыг ялган олж, эдгээрт суурилан Хүннүгийн угсаа гарлын асуудлыг цоо шинээр авч үзэж болно.

2. Баримтын эмпирик шинжилгээ

Цагаан хэрмийн (长城) бүс нутагт Хавар намрын улсын (春秋) сүүл болоод Байлдаант улсын (战国) үед хамаарах умардын угсаатнуудаас үлдэж хоцорсон олдворуудыг ерөнхийд нь харвал дараах хэдэн бүсэд ангилан үзэж болох мэт.

А бүс: Хөбэй (河北) мужийн умард хэсэг, Сангань голын (桑干河) дунд урсгалд Яньраньшань уулаар (燕然山) төвлөрсөн бүс. Үндсэн дурсгалт газрууд нь Яньчингийн (延庆) Хулугоу (葫芦沟), Силянгуан (西梁坳), Юхуанмяо (玉皇庙) зэрэг газар дахь булш, дурсгалууд^{1,2}, Хуайлайгийн (怀来) Бэйсинь (北辛) тосгоны оршуулга³, Сюаньхуагийн (宣化) Сяобайянгийн (小白阳) булш⁴, Жанчхүүгийн (张家口) Цагаан сүмийн (白庙) булш ба бууц зэрэг болно⁵.

В бүс: Өвөр Монголын Иньшань (阴山- Далан хар) уулын дорнод биеийн өвөр газар. Үндсэн дурсгалт газрууд нь Лянчэн (凉城) сяний Маоцингоугийн (毛庆沟) булш ба бууц⁶, Иньнюгоугийн (饮牛沟) булш⁷, Гуо (崞) сяний яозыгийн (窑子) булш⁸, Хорингэр (和林格尔) сяний Фаньжя (范家) яозыгийн (窑子) хүрэл эдлэл⁹, Түмэд (土默特) хошууны Шүйжянь Гоумэний (水涧沟门) хүрэл эдлэл зэрэг болно¹⁰.

С бүс: Өвөр Монголын Бор тохойн (河套) зүүн хойд бие. Үндсэн дурсгалт газрууд нь Зүүнгар хошууны (准格尔旗) Баохайшэ (宝亥社) -гийн хүрэл эдлэл¹¹, Сүжигуо (速机沟) -гийн хүрэл эдлэл¹², Халату (哈拉图) -гийн булш, Сыгоупань (西沟畔) -ий оршуулга¹³, Юлунтай (玉隆太) -гийн булш¹⁴, Ваартын (瓦尔吐) хүрэл эдлэл^{15, 16}, Хангин хошууны (杭锦旗) Гунсүжя (公苏嫁) -гийн булш, Таохунбала (桃红巴拉) -гийн булш¹⁷, Алучайдэн (阿鲁柴登) -гийн алт, мөнгөн эдлэл¹⁸, Дуншэн (东胜) дүүргийн Няньфанцо (碾房渠) -гийн алт, мөнгөн эдлэл¹⁹ зэрэг болно.

¹ 北京市文物研究所山戎文化考古队:《北京延庆军都山东周山戎部落墓地发掘纪略》,《文物》1989年8期。

² 北京市文物研究所编:《北京考古四十年》,北京燕山出版社,1990年。

³ 河北省文化文物工作队:《河北怀来北辛堡战国墓》,《考古》1966年5期。

⁴ 张家口市文物事业管理所等:《河北宣化县小白阳墓地发掘报告》,《文物》1987年5期。

⁵ 张家口市文物事业管理所:《张家口市白庙遗址清理简报》,《文物》1985年10期。

⁶ 内蒙古文物工作队:《毛庆沟墓地》,见《鄂尔多斯式青铜器》,文物出版社,1986年。

⁷ 内蒙古自治区文物工作队:《凉城饮牛沟墓葬清理简报》,《内蒙古文物考古》第3期,1984年。

⁸ 内蒙古文物考古研究所:《凉城崞县窑子墓地》,《考古学报》1989年1期。

⁹ 李逸友:《内蒙古和林格尔县出土的铜器》,《文物》1959年6期。

¹⁰ 郑隆:《大青山下发现一批铜器》,《文物》1965年2期。

¹¹ 伊克昭盟文物工作站:《内蒙古准格尔旗宝亥社发现青铜器》,《文物》1987年12期。

¹² 盖山林:《内蒙古自治区准格尔旗速机沟出土一批铜器》,《文物》1965年2期。

¹³ 伊克昭盟文物站等:《西沟畔匈奴墓》,《文物》1980年7期。

¹⁴ 内蒙古博物馆等:《内蒙古准格尔旗玉隆太的匈奴墓》,《考古》1977年2期。

¹⁵ 内蒙古文物工作组:《几年来的内蒙古文物工作》,《文物参考资料》1957年4期。

¹⁶ 内蒙古文物工作队:《内蒙古出土文物选集》,文物出版社,1963年。

¹⁷ 田广金:《桃红巴拉的匈奴墓》,《考古学报》1976年1期。

¹⁸ 田广金、郭素新:《内蒙古阿鲁柴登发现的匈奴遗物》,《考古》1980年4期。

¹⁹ 伊克昭盟文物工作站:《内蒙古东胜市碾房渠发现金银器窖藏》,《考古》1991年5期。

Д бүс: Нинся (宁夏) -гийн өмнөд бие дэх Чиншуй (清水) голын сав. Үндсэн дурсгалт газрууд нь Жунвэй (中卫) -гийн Ланвозыкэн (狼窝子坑) -гийн оршуулга²⁰, Жуннингийн (中宁) Нидин (倪丁) тосгоны оршуулгын газар²¹, Пэнян (彭阳) -гийн Мэнюань (孟塬) суурингийн оршуулгын газар, Байянлин (白杨林) тосгоны оршуулгын газар ба бусад олдворууд²², Гуюан (固原) -ий Шила (石喇叭) тосгоны оршуулгын газар²³, Яргуй оршуулгын газар, Жянхө (蒋河) оршуулгын газар²⁴, Дабэй уул (大北山) ба Пинлө (平乐) -гийн оршуулгын газар²⁵, Чэмэн (撤门) тосгоны оршуулга, Лузыгоу ам (芦子沟嘴) -ны оршуулга, Тяньва (田洼) -гийн оршуулга, Хоумо (侯磨) тосгоны оршуулга ба бусад олдворууд²⁶, Сизи (西吉) -гийн хэлбэрийн ховилтой хүрэл эдлэлүүд, Чэньянчуань (陈阳川) -ий оршуулгын газар ба бусад олдворууд²⁷.

Е бүс: Ганьсу (甘肃) мужийн дорнод хэсэг дэх Цинян (庆阳) хотын орчим. Үндсэн дурсгалт газрууд нь Нин сян (宁县) -ий Юаньжя (袁家) тосгоны оршуулга²⁶, Жэньюань (镇原) -ий Мяоцю (庙渠) гацааны оршуулга, Хунянь (红岩) -ий оршуулга, Ужягоу (吴家沟) тойргийн хүрэл эдлэл²⁶, Жэннин (正宁) -гийн Хоужан (后庄) -гийн оршуулга²⁵, Цинянгийн Улипо (五里坡) -гийн морьтой булш²⁷ ба бэхлэлт, Лигоу (李沟) зэрэг газрын бусад олдворууд²⁶.

Ү бүс: Өвөр Монголын Иньшань уул (阴山) -ын баруун бие. Үндсэн олдворууд нь Ураад (乌拉特) дунд ба хойд хошууны Хулстайн (呼鲁斯太) оршуулга²⁸.

Дээр дурдсан зургаан бүс нутаг олон тооны нийтлэг соёлын элементтэй, үүнд Хавар намрын улсын сүүл үеэс Байлдаант улсын эхэн үеийг хүртэл хамаарах зарим үндсэн олдворуудыг сонгон 1-р зурагт үзүүлэв. Зургаан бүс нутгийн оршуулганд мэдээж бүгдэд нь морь, үхэр, хонь дагалдуулжээ. Үүнээс үзэхэд, тухайн цаг үеийнхээ “тэргүүний улсын” хүний нүдэнд дээрх зургаан бүс нутгийн хүмүүс хоорондоо адил соёлын хэв шинжтэй харагдаж байжээ.

Гэвч нарийн шинжилвэл, зургаан бүс нутаг нь харилцан ялгаатай болохыг олж харж болох ба цэвэр археологийн үүднээс хандвал, тэдгээрийг археологийн нэгэн соёлын дор оруулах боломжгүй юм.

Бүс тус бүрийн булшинд дагалдуулсан шавар ваарнуудын ялгаа маш тодорхой байна. 2-р зурагт бүс тус бүрийн шавар ваарны нийтлэг шинжүүдийг харьцуулсан ба үүнд зарим нэмэлт тайлбар хийх шаардлагатай.

А бүсийн вааран эдлэлийг хоёр бүлэгт хувааж болно. Саарал шавар вааран аяга (泥质灰陶的) ба ирмэг мөртэй бортого (折肩罐) бол Хятад газрын соёлын нөлөөний бүтээгдэхүүн юм (2-р зургийн 1, 2). Элсэрхэг вааран эдлэлийн хамгийн түгээмэл хэлбэр нь богино, цүдгэр гэдэс бөгөөд (2-р зургийн 3), гурван хөлт хос чихтэй ваар төдий олонгүй байдаг онцлогтой (2-р зургийн 4).

²⁰ 周兴华: 《宁夏中卫县狼窝子坑的青铜短剑墓》, 《考古》1989年11期.

²¹ 钟侃: 《宁夏中宁县青铜短剑墓清理简报》, 《考古》1987年9期.

²² 罗丰、韩孔乐: 《宁夏固原近年发现的北方系青铜器》, 《考古》1990年5期:

²³ 罗丰: 《宁夏固原县石喇叭村发现·座战国墓》, 《考古学集刊》3, 1983年

²⁴ 钟侃: 《宁夏固原县出土的文物》, 《文物》1978年12期.

²⁵ 总钟侃、韩孔乐: 《宁夏南部春秋战国时期的青铜文化》见《中国考古学会第四次年会论文集》. 文物出版社, 1985年.

²⁶ 刘得祯、许俊臣: 《甘肃庆阳春秋战国墓葬的清理》, 《考古》1988年5期

²⁷ 庆阳地区博物怕等: 《甘肃庆阳城北发现战国时期葬马坑》, 《考古》1988年9期

²⁸ 塔拉、梁京明: 《呼鲁斯太匈奴墓》, 《文物》1980年7期,

Б бүсийн тухайд, Маоцингоу ба Иньюнгоу (饮牛沟) -гийн вааран эдлэл адил төстэй, харин Гуо сяний гаралтай вааран эдлэл ба өмнөх хоёр газрын вааран эдлэлийн хооронд мэдэгдэхүйц ялгаатай тул үндсэнд нь хоёр бүлэгт хуваадаг. Гуо сяний вааран эдлэл дийлэнхдээ хос чихтэй, $\frac{3}{4}$ нь цулгай гадаргатай ба хос чихтэй цулгай бортого нийт вааран эдлэлийн тэн хагасыг эзэлнэ. Маоцингоу-гийн вааран эдлэл хэе чимэглэлтэй, халууны боловсруулалт өндөр, эргэх хүрд ашиглаж хийсэн, хятад газрын технологийн илт тодорхой нөлөөтэй, тэдгээрийн 85 хувь нь чихгүй, цөөн тооны ваарны мөрөн дээр долгионт хэе зурсан нь нэн анхаарал татахуйц юм.

Дээрх хоёр бүс нутагт чих болон амсар тэнцүү буюу чих нь амсраас өндрөвтөр, хос чихтэй будаггүй ваар савнууд олддог нь тус хоёр бүс нутгийн соёлын харилцааг харуулж байна. Гэвч энэ төрлийн ваар сав цөөн тоотой, эзлэх хувь бага тул харилцан ялгаатай археологийн соёлуудын хоорондын соёлын элементийн солилцоо төдий харагддаг. Анхаарал татахуйц зүйл нь Таншань (唐山) -ий Жягэжуан (贾各庄) дахь Янь улсын оршуулгын газарт мөн энэ төрлийн хос чихтэй, гурван хөлт ваар олдсон ба Гуо сяний богино хүзүү, хоё чихтэй ваартай төстэй байдаг²⁹. Ляонин (辽宁) мужийн Казуо (喀左) дахь чулуун авст булшинд Гуо сяний шатаах зуухныхтай адил төстэй “хос чихт ваар” болон хятад газрын хийцийн гурван хөлт шавар ваар нийтлэг олддог³⁰. Ганьсу (甘肃) мужийн Юнчангийн (永昌) Шажин (沙井) соёлын олдворууд дотор мөн адил төстэй хос чихт ваар бий (3-р зураг).


С бүсийн булш дотор шавар ваар цөөн олддог ба бүгд будаггүй, гар хийцийнх. Үндсэндээ нэг чихтэй, хүзүүтэй. С14-ийн шинжилгээгээр Хавар намрын улсын үед холбогдох Таохунбала (桃红巴拉)-гийн М-1-ээс ийм төрлийн шавар ваар олдсон. Сигоу (西沟) сав газрын М-2-оос олдсон бүх алт, мөнгөн эдлэл дээрх дүр дүрслэл нь уг булшийг Цинь улс ба түүнээс өмнөх үед хамаарч болохыг харуулдаг бөгөөд шавар ваарных нь Халатугийн (哈拉图) М-3-аас гарсан нэг чихтэй ваарны хийцтэй ижил байна (2-р зургийн 18). Хэрэв алдаагүй бол, энэ төрлийн шавар ваар нь С бүсэд маш урт хугацаанд оршсон бөгөөд уг бүс нутгийн оршин суугчид ч урт хугацаанд өөрчлөгдөөгүй гэж үзэж болно.

D бүс дэх Хавар намрын улсын сүүл үе ба Байлдаант улсын эхэн үед холбогдох булшны шавар ваарнууд нь одоогоор зөвхөн Чиншүй (清水) гол Шар мөрөнд цутгадаг сав нутгаар олоод байгаа. Нидин тосгон (倪丁村) болон Ланвозыкэнгийн (狼窝子坑) шавар ваарны харагдах байдал адил бөгөөд бүгдэнд нь бүслүүргүй (无领带) чихтэй шавар ваар ба шавар халбага үндсэн бүрдэл болдог. Шавар халбага буюу чулуун эдлэлүүдийг Таохунбалагийн (桃红巴拉) М2 булшны “чулуун аяганы төрлийн эдлэл”-тэй адил гэж таамаглаж болох бөгөөд С, D бүсийн хоорондын харилцааг харуулж байна (2-р зургийн 19, 20, 25).

Чиншүй голын дээд урсгалд байх харьцангуй эрт үеийн булшнуудаас өнөөг хүртэл шавар ваар олноогүй, E бүсэд булш маш цөөн бөгөөд шавар ваар илэрдэггүй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Тухайн бүс нутагт булшинд шавар ваар дагалдуулах уламжлал оршин байсан эсэхийг тодорхойлох боломжгүй юм.

²⁹ 安志敏: 《河北省唐山市贾各庄发掘报告》, 《考古学报》第六册, 1953年:

³⁰ 傅宗德、陈莉: 《辽宁喀左县出土战国器物》, 《考古》1988年7期.



1-р зураг (1)

А бүс: 1, 4, 9, 11. Бэйсиньбао (北辛堡)

2, 5, 6, 10. Юхуанмяо (玉皇庙)


3. Хулугоу (葫芦沟)

8, 12, 13. Сяобайян (小白阳)

В бүс: 1, 3-7, 10, 13. Маоянгоу (毛央沟). 2. Шүйжяньгоумэн (水涧沟门).

8, 9. Гуо сянь (崮县)

Ф бүс: 6. Хулстай (呼鲁斯太)



1-р зураг (2)

С бүс:

1-3, 14. Гунсүхао (公苏壕)

4-13. Таохунбала (桃红巴拉)

Д бүс:

1, 2. Шила тосгон (石喇村)

8-11, 13, 15. Самэн тосгон (撒门村)

14. Хузы жалгын ам (户子沟嘴)

Е бүс:

1. Ли жалга (李沟)


2. Ма бэхлэлт (马寨)

3, 5, 6. Мяо суваг (庙渠)

4, 7. Юаньжя тосгон (袁家村)

8, 9, 17. Улаан хясаа (红岩)

10. Ужя жалгын тойрог (吴家沟圈)



2-р зураг

А бүс: 1, 3. Ихуанмяо (玉皇庙) 2, 4. Хулугоу (葫芦沟) 5. Баймяо (白庙)
 В бүс: 6-10. Хэнсянмяо (亭县窑子) 11-15. Маоцингоу (毛庆沟)
 С бүс: 16, 17, 19, 20. Гаохунбала (桃红巴拉) 18. Халату (哈拉图).
 D бүс: 21-23, 25-26. Ланвозыкэн (狼窝子坑) 24. Нидин тосгон (倪丁村) 28, 29.
 Хоумо тосгон (候磨村) 30. Чэньянчуан тосгон (陈阳川村)
 F бүс: 27. Хулустай (呼鲁斯太)

Чин-шүй голын дээд бие дэх Гу-юань (固原) -ий Хоумо (候磨) ба Сизыгийн Чэньянчуан (陈阳川) тосгоны булшнуудаас саман хээтэй вааран эдлэл алтан эдлэлийн хамтаар гардаг бөгөөд эдгээрийн цаг хугацаа нь Байлдаант улсын дунд үеэс хожуугүй бололтой. Зарим судлаач тэдгээрийг В бүсийн шавар ваартай төстэй болохыг тэмдэглэсэн³¹ нь нэн сонирхолтой юм.

Ү бүсийн Хулстайгаас 7 ширхэг улаан будагт ваар олдсоны дотор харьцангуй бүрэн бүтэн байдалтай, урт хүзүүтэй, хос чихтэй ваар бий (тайланд “мөр хэсэгт долгиолсон хээтэй” гэсэн боловч нийтлэгдсэн зурагт тодорхой харагдахгүй, мөн түүнчлэн 2-р зурагт үзүүлээгүй). Энэ вааран эдлэл маш онцлогтой ба баруун нутгийн будагтай шавар ваартай холбогдох боломжтой.

Вааран эдлэлийн онцлог ялгаатай шинжийг зарим археологич чухалчлан үздэг боловч зарим археологич үүнийг чухалд үздэггүй бөгөөд иймээс энэхүү хоёр өөр үзлийн соёлын ялгаатай асуудлыг авч үзэхийг хичээе.


Нэгдүгээрт, дээд дурдсан бүсүүд хөгжингүй мал аж ахуйтай байсан нь эргэлзээгүй боловч бүс тус бүрийн малын төрөл харилцан адилгүй байна. А бүсэд морь, үхэр, хониноос гадна нохой түгээмэл төдийгүй оршуулгад дагалдуулах нь хамгийн олон байна. Бусад бүсүүдийн тухайд В бүсийн Гуо сяний бүлэг суурингаас бусдад нь нохой дагалдуулсан оршуулга илрээгүй. Гуо сяний бүлэг сууринд нохойноос гадна гахай дагалдуулсан ба “Гуо М8”, “Гуо М19” булшнуудад гахай ба нохойны толгойг хосоор нь тавьсан байна. Энэ хоёр булш эмэгтэй хүнийх ба гахайн толгой нь гэршүүлсэн гахайнх бололтой. Энэ байдал тус суурингийн оршин суугчдын амьдралын хэлбэр, онцлогийг тусган харуулж байна. Мөн түүнчлэн тус газрын дөрвөн оршуулганд зэрлэг буга дагалдуулсан байв. Эдгээр нь өвөрмөц зан заншил, уламжлалаас гадна эдийн засгийн байгууллын онцлогийг тусгасан байх боломжтой. Е бүсийн булшнуудад бүтэн адууг булшны нүхнээс тусдаа нүхэнд тавих хэлбэр нийтлэг бол энэ хэлбэр бусад бүсэд ажиглагдаагүй. Баймяогийн (白庙) дурсгалт газрын хөрсний давхаргын зузаан 0.5 метрээс багагүй, Маоцингоугийн хөрсний давхарга 1 метрээс багагүй, мөн түүнчлэн ваар шатаах зуух болон ясан урлалын газрууд байдаг бөгөөд эдгээр нь бүгд хүн урт хугацаанд оршин сууж байсны баримт юм. Эндээс үзэхэд, тухайн үеийн Цагаан хэрмийн бүс нутаг дахь малчин ард түмнүүд эдийн засаг, амьдралын хэлбэр, ёс заншлаараа адилгүй байсныг ойлгож болно.

Хоёрдугаарт, “дайтж сурах нь довтолгооныг эсэргүүцэхээс эхэлдэг” (人习战攻以侵伐) гэх үгийн ёсоор, бүс тус бүрийн зэр зэвсэг илэрхий ялгаатай байна. D болон E бүсийн жад ихээхэн боловсронгуй бол бусад бүсэд илрээгүй (Маоцингоугийн M58-д нэг илэрсэн боловч энэ нь Хятад газрын бүтээгдэхүүн байна). Б бүс болон баруун бүс нутагт өргөн тархсан “тогоруун сүх” (鹤嘴斧) А бүсэд огт илрээгүй. Б бүсийн Гуо сяний суурингуудад хараацай сүүлт зэв бол ясан зэвэн дунд хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд харин баруун бүс нутагт энэ төрлийн зэв илэрдэггүй.

Бүс бүрд өргөн тархсан чинжаал хутганы судалгааг үзвэл, нэг талаар, “скиф загварын” чинжаал бүгдэд нь ижил тархсан боловч нөгөө талаар бүс бүр өвөрмөц онцлогтой бөгөөд харилцан адилгүй соёлын нөлөө туссан байна. А бүсэд өргөн

³¹ 甘肃省博物馆文物工作队等：《甘肃永昌三角城沙井文化遗址调查》，《考古》1984年7期：

тархсан чинжаал нь тус бүсэд өмнө байсан чинжаал дээр үндэслэн хятад газрын чинжаалын нөлөөгөөр хэлбэршсэн бөгөөд (4-р зураг) бусад бүсэд илэрдэггүй. В бүс болон түүнээс баруунш олддог ихэнх илднүүд тэр бүр скиф загварынх биш бөгөөд тэдгээрт бариулын ойр байрлах хонхор нүх болон махир хэлбэртэй ир нийтлэг. Энэ нь Жоугийн эхэн үеийн уламжлал тус бүс нутагт нөлөөлсний нотолгоо юм (5-р зураг). Энэ төрлийн илд А бүсэд хараахан олдоогүй байна. Бүс бүрийн бариулын хийц ба чимэглэлийн аргууд харилцан ялгаатай боловч тус өгүүлэлд тусгайлан авч үзэхгүй. Энд зөвхөн ганц жишээ дурьдахад, сэрээ хэлбэрийн хамгаалалттай хүрэл илд болон зэс бариултай төмөр илднүүд D ба E бүсэд олддог бол Цагаан хэрмийн дагуух бусад бүс нутагт илрээгүй. Харин Сычуаний баруун³² ба Юннаний баруун нутгаар³³ түгээмэл олддог (7-р зураг). Энэ нь умардын тал нутгийн хүрлийн соёл өмнө зүгт түгсэн тухай нэгэн чухал шижмийг бий болгожээ.




3-р зураг

- 1, 2. Хөбэй мужийн Тан уулын Жягөжуан дахь Янь улсын үеийн оршуулга
- 3, 4. Ляонин мужийн Харчин зүүн хошууны (喀左) чулуун хашлагат булш (石槨墓)
5. Ганьсу мужийн Юнчангийн (永昌) Сань-жяо хот (三角城)


³² 安志敏:《四川甘孜附近出土的一批铜器》,《考古通讯》1958年1期;会理县文化馆:《四川会理出土的一面铜鼓》,《考古》1977年3期;《泸沽湖畔出土文物调查记》,《凉山彝族奴隶制研究》1978年1期。

³³ 云南省博物馆文物工作队:《云南德钦永芝发现的古墓葬》,《考古》1975年2期;云南省博物馆文物工作队:《云南德钦县石底占基》,《考古》1983年3期;云南省博物馆文物工作队:《云南宁蒗县大兴镇占墓葬》,《考古》1983年3期;大理县文化馆:《云南大理收集到一批汉代铜器》,《考古》1966年4期;张增祺:《云南祥云大波那发现木槨铜棺墓》,《考古》1964年7期;云南省博物馆文物工作队等:《云南楚雄县万家坝古墓群发掘简报》,《文物》1978年10期;童恩正:《我国西南地区青铜剑的研究》,《考古学报》1977年2期。



4-р зураг

1. Өвөр Монголын Онгуд хошууны Дапаозы дахь Баруун Жоугийн үеийн булш
2. Хөбэй мужийн Луанпин сяний Байцигийн Жуанчангийн булш
3. Жанчхүүгийн Баймяогийн түүвэр олдвор
- 4,5. Сюаньхуагийн Сяобайянгийн булш



5-р зураг

1. Чанпингийн Байфугийн Сижоу дахь булшны олдвор
2. Ордосын олдвор (“Nei Menggu Changcheng didai”-аас)
3. Шаньсигийн олдвор (Watson, Cultural Frontiers Ancient East Asia, 1971, 82-р зураг)
4. Хорингэрийн Фаньжягийн олдвор
5. Зүүнгар хошууны Сигоугийн олдвор
6. Жуннин сяний Нидин тосгон

Мэдээж урьд өмнөх олон судлаач дээрх зургаан бүсийн хоорондын үлдсэн бусад ялгааг онцлон үзэж ирсэн бөгөөд уг зургаан бүсийг археологийн нэг соёл гэж үзсэн нэг ч археологич байхгүй юм. Гэвч зарим хүн эдгээр ялгаатай соёлуудад адил төстэй элемент бий бөгөөд нэг эх соёл хөгжлийн явцдаа салбарлан ондоошсон учир нэг том үндэстний олон салбарууд гэж үздэг. Энэ байр суурийг ажиглавал эндээс Сыма Цяний үзэл “үнэртдэг”. Учир нь Сыма Цянь хүннүгийн өвөг Чуньвэйг “Ся Хоужигийн удам” хэмээгээд Хүннү ба Хань улсын хоорондын ялгавартай байдлыг ондоошлын үр дагавар болгожээ. Гэвч археологийн судалгаагаар олдсон хүний ясанд хийгдэж буй антропологийн судалгааны тасралтгүй хөгжлийн үр дүнд дээрх таамаглал улам бүр үндэслэлгүй болж байна.

А бүсийн Баймяогийн булшнаас (1978-1979 онд НШУА-ийн Археологийн хүрээлэн 100 гаруй булш малтан судалсан) хүний яс илрүүлж, урьдчилсан байдлаар хоёр физик хэв шинжтэй гэж үзжээ. Үүнээс Баймяо I бүлэг нь “Дорнод Азийн хэв шинжтэй ойр холбоо бүхий” ба Сяжядянь (夏家店) -ий дээд давхаргын соёлын хүнтэй ойролцоо бол Баймяо II бүлэг нь Умард азийн хэв шинжийг түлхүү агуулах ба Сяжядяний дээд давхаргын соёлын хүнээс ялгаатай байв³⁴.

В бүсийн Маоцингоугаас олдсон хүний ясыг мөн шинжилсэн бий. Уг булшны байдал Баймяогийнхтай адилгүй. Баймяо-I ба Баймяо-II булшнуудад оршуулгын зан үйлийн онц ялгаа байхгүй ба соёлын хувьд мөн адил төстэй. Маоцингоугийн булшинд оршуулгын хоёр өөр зан үйл цуг байх нь бий. Өмнө-умард чиглэлтэй булшнуудад малын толгой дагалдуулдаггүй бөгөөд бүсний дэгээг эс тооцвол маш цөөн эдлэл гардаг. Ихэнхэд нь бүсний дэгээг хоёр хувааж толгой ба хөлний харалдаа тавьдаг. Дорнод-өрнөд чиглэлтэй булшнуудад малын толгой түгээмэл илэрдэг ба төрөл бүрийн эдлэл дагалдуулж, хэвлий хавьд бүсний арал дагалдуулдаг. Инъюгоу (饮牛沟) -гийн булш Маоцингоутай адил хоёр төрлийн оршуулгын зан үйлтэй ба антропологийн судалгааны үр дүн мөн адил гарсан³⁵. Эндээс үзэхэд, нэгэн бүлэг иргэн дотор амьдралын хоёр өөр хэлбэр оршин байж, ёс заншлын хувьд хараахан харилцан уусаагүй байжээ.

В бүсийн Гуо сяний булшнууд Маоцингоугаас зөвхөн ваар савны талаар өөр төдийгүй, гавлын ясны судалгаанаас үзэхэд Зүүн Азийн зарим хэв шинжийг агуулсан Умард Азийн хэв шинж тодорхой илэрдэг³⁶. Дээрх оршуулгын газрын булшнуудад нум, сумнаас өөр зэр зэвсгийн зүйл дагалдуулдаггүй. Одоогоор, Цинь (秦) улсын өмнөх үед холбогдох Цагаан хэрмийн бүсэд зөвхөн дээрх оршуулгын газраас энэ зан үйл илрээд байна.

С бүсэд одоогоор зөвхөн нэг эрэгтэй хүний бүтэн бус гавлын ясны хэв шинжийг тодорхойлоод байгаа³⁷ бөгөөд зарим хэмжилтээс үзэхэд “Ази тивийн монголжуу төрхтний Умард Азийн хэв шинжтэй адилавар байна”³⁴. Бүрэн бус мэдээлэл ба ганц өгөгдөл дээр дээр үндэслэн С бүсийн антропологийн хэв шинжийг тодорхойлох нь маш хэцүү юм.

³⁴ 潘其风：《从颅骨资料看匈奴的人种》，见《中国考古学研究——夏前先生考古五十年纪念论文集》，科学出版社，1986年。

³⁵ 潘其风：《内蒙古凉城毛庆沟匈奴墓人骨的研究》，见《鄂尔多斯式青铜器》，文物出版社，1986年。

³⁶ 朱泓：《内蒙古凉城东周时期墓葬人骨研究》，《考古学集刊》7，科学出版社，1991年。

³⁷ 潘其风、韩康信：《内蒙古桃红巴拉占墓和青海大通匈奴墓人骨的研究》，《考古》1984年4期

А ба В бүсүүдэд хийсэн судалгаагаар хүний соёо шүдний хоёр өөр физик хэлбэр зэрэгцэн оршиж байсныг тодорхойлж, Цагаан хэрмийн бүс нутагт нийтлэг хүчин зүйл бүхий олон төрлийн өвөрмөц соёлууд оршин байсныг харуулжээ. Эдгээр нь нэг угсаа гаралтнуудын соёлын ондоошлоор бүрэлдээгүй, харин өөр угсаа гаралтнуудын харилцан үйлчлэлийн үр дүн байв.

“Хүннүгийн шастирт” Хавар, намрын улсын үеийн умардын оршин суугчдын талаар бичихдээ: “Тус тусдаа салангид сууцгаах ба өөртөө удирдагчтай, үе үе Жунгийн нэрээр цуглардаг (往往而聚者余戎), гэвч харилцан нэгддэггүй” хэмээжээ. Бидний шинжилж үзсэн эдгээр соёлын ба угсаа гарлын нийтлэгүүдэд хэрэв бат тогтвортой холбоо бүрэлдээгүй нөхцөлд бид өргөн хэмжээний угсаатны ижилслийг дэвшүүлэн тавих талаар төсөөлөх ч боломжгүй юм.

Товч дүгнэхэд, хожмын Модуний Хүннүгийн холбоо бол умардад нэгэнт бүрэлдсэн томоохон угсаатны бүлгийн суурин дээр байгуулагдсан явдал огт биш, харин оршин байсан олон тооны жижиг угсаатны бүлгүүд дээр үндэслэсэн ажээ. Эдгээр угсаатны бүлгүүдийн морфологи болон соёлын онцлог нь харилцан огт өөр байв. Үүнд үндэслэн Хүннүгийн угсаа гарлыг нэхэн үзвэл, үнэн хэрэгтээ Модуний бий болгосон холбооны гол цөм нь ямарваа морфологи ба соёлын онцлог бүхий зарим нэг буюу хэд хэдэн харьцангуй жижиг угсаатны бүлгүүд байж (учир нь Модунаас өмнөх үеийг хянавал Хүннүгийн холбоо дотроо хэд хэдэн угсаатны бүлгийн жижиг нийтлэгийг агуулж байв), ийнхүү Сыма Цяниас нэг алхам урагшлах боломжтой юм.

Гурав. Угсаатан бүрэлдэх асуудлыг хэлэлцэх нь

Ингэхээр, дээр авч үзсэн зургаан бүс нутаг дахь угсаатны бүлгүүдээс эцэстээ аль нь язгуурын Хүннүгийн уг эх вэ? А бүсийн дурсгалуудыг нэгэнт “Уулын Жунгийн (山戎) соёл” гэх нэрлээд уджээ. Харин цаг үе ба газрыг харвал үнэндээ Жао улсад мөхөөгдсөн Дай (代) улс юм.

А бүсийн дурсгалуудын дунд хятад газрын хийцтэй ёслолын зүйлс, морин тэргийн хэрэгсэл ба өдөр тутмын бусад эдлэлүүд олноор бий (тухайлбал, жижиг хугта, бүсний дэгээ, түрүү үеийн шоубү 首布 хэмээх шовх зоос). Тэдгээрийн ихэнх хэсэг нь бүгд Хавар намрын улсын сүүл үеэс Байлдаант улсын эхэн үеийнх бөгөөд харин Байлдаант улсын дунд үед хамаарах зүйлс байхгүй. Энэ нь “Түүхийн тэмдэглэлийн” Жао Сянзы (赵襄子) гийн анхдугаар онд (НТӨ 457) “Дай улсыг” мөхөөсөн тухай бичгийн мэдээтэй тохирдог.

Хавар, Намрын улсын үеийн Дай улсын газар нутгийн тухайд, Хань улсын үеийн Дай сянийг түүхчид өнөөгийн Ю сянь (蔚县) -ий нутаг Сангань голын баруун биеэр бий гэж үзэж иржээ. Гэвч Сянзыгийн Дай улсыг мөхөөх үеэр нэгэн эмгэнэлт явдал болсон нь: түүний эгч Дай улсын вангийн хатан байж, иймээс Сянзы заль мэх хэрэглэн түүний нөхрийг алж, Дай улсыг сөнөөв. Сянзы түүнийг элчид авахуулан улсдаа буцаахаар илгээхэд тэр уулнаа гарч үсний хатгуураар амиа хорлов. Байлдаант улсын үед Жан И энэ явдлын талаар “Эрт цагаас эдүгээ хүртэл Можи (磨笄) уул оршив, тэнгэрийн доор хэн ч түүнийг эс мэдэв” хэмээн бичжээ (Байлдаант улсын бодлогын бичиг, Янь 1, Цинь улсын төлөөнөө Жан И өмнөд-умардын холбоолсныг эвдсэн нь). Можи уулын байршлын талаар “Шүйжинжү” (水经注) -д бичсэнээр, Лэйшүй (灤水-өнөөгийн Сангань гол), “Вэйгийн газар нутгийн тэмдэглэл” (魏

土地记) -ийн дагуу бол хоёр адилгүй өгүүлэл бий, нэгдүгээрх нь өнөөгийн Ю (蔚) сянний дорно этгээдэд бол хоёрдугаарх нь өнөөгийн Жуолу (涿鹿) тойргийн зүүн хойно, Яньрань (燕然) уулын баруун өмнөд талын Живу (鸡鸣) уул бөгөөд энэ хоёр газарт аль алинд нь Дай улсын хатны тахилга бий. Хэрэв Дай улс Ю сянний нутагт байсан бол, нутгийнхны уламжлалаар Яньрань уулын нутаг дахь ахин өөр нэг Можи уул яагаад гарч ирэв? Одоо бид Яньрань уулын бүсэд Хавар намрын улс ба Байлдаант улсын үеийн хооронд оршин байгаад гэнэт мөхсөн нэгэн бүлгийг нэгэнт мэдэх болсон бөгөөд мөн түүнчлэн Ю сянний нутагт хийсэн археологийн илүү нарийвчилсан хайгуулаас үзэхэд ижил төстэй нөхцөл байдал илрээгүй. Үнэн хэрэгтээ, Живу уул бол эртний Можи уул мөн хэмээн зөвшөөрөх ёстой. Ю сянний дорнодод буй тэр нэг байршил бол хожим үүссэн хуурамч цуу юм. “Шүйжинжү” сурвалжийн Өрнөд Хань улсын үеийн Мэйфү (梅福) -гийн хэрэгт өгүүлэх нь, “Дай хөндийн өмнөдөд Хэншань (恒山), умардад Умард боомт (北塞) бий. Хөндийн дорно этгээдэд өндөрлөг, өрнөд этгээдэд Дай газар бий” гэжээ. Үүнээс үзэхэд, Хань улсын үеийн Сангань голын хөндийг бүхэлд нь Дай хөндий гэж нэрлэсэн ба Хавар, намрын улсын үеийн Дай газар нь энэ хөндийн дорнод хэсгийг хамарч байна. Энэ нь эртний газарзүйн онолтой зөрчилдөхгүй юм.

“Мозы (墨子)”-гийн “Түрэмгийллийг буруутгахуй, дунд” (非功中) ба “Түгээмэл хайр” (兼爱中) сурвалжуудын аль алинд “Янь, Дай, Ху, Мо (燕, 代, 胡, 貉)” нарыг зэрэгцүүлж бичжээ. “Хүннүгийн шастирт”, “Жао Сянзы Дай улсыг мөхөөж, Линьху, Мо (临胡, 貉) гэж нэрлэсэн” гэснээс үзэхэд Дай улс бол Ху биш байна. “Түүхийн тэмдэглэлийн” “Жао удмын намтар” (赵世家) бүлэгт өгүүлэхдээ, Жао Зяньзы-д Тэнгэрийн хаан хөвгүүнээ (хожмын Жао Сянзы) нэг гургуул, нохойн [хамт – орч.] өгч, Дай улсыг сөнөөхийн бэлгэдэл болгосон” хэмээн бичсэнээс үндэслэн Дай бол Ди (狄) нарын байгуулсан улс гэж болно. Тэд Байлдаант улсын үеийн эхэн гэхэд нэгэнт сөнөсөн байсан бөгөөд үнэн хэрэгтээ язгуурын Хүннүгийн уг эх биш байв.

Д бүсийн өмнөд хэсгийн Гүюань (固原) бүс нь Хавар, намрын улсын хожуу үе ба Цинь, Хань улсын хооронд хамаарна. Луофэн (罗丰) үүнийг “Хүннүгийн шастирт” тэмдэглэгдсэн “Ушигийн (乌氏) жун”³⁸ гэж үзсэн нь оновчтой байна. “Хүннүгийн шастирт” Уши бол Жиншүй (泾水) голын умардад байх Жунгийн аймгуудын нэг гэжээ. “Хань улсын судрын (汉书)” “Газарзүйн ойллого (地理志)” бүлэгт Уши сянний талаар “Ушүй (乌水) -гийн ус баруун хойш голд нийлнэ, өрнөд этгээдэд нь Дүлү уул (都卢山) буй” хэмээжээ. Жиншүйгээс (泾水) умардад зөвхөн Чиншүй (清水) гол баруун хойш урсан Шар мөрөнд (黄河), бусад нь өмнө зүгт Вэй голд (渭河) цутгана. Гүюань (固原) бол үнэндээ Чиншүй голын эх авсан газар ба баруунд нь мөн Люпань уул (六盘山) буй. Ушүй бол өнөөгийн Чиншүй гол, Дүлү уул бол өнөөгийн Люпань уул мөн нь эргэлзээгүй. Гүюаний Гүчен сян (古城乡) -гийн Гүчен тосгон (古城村) -д хийсэн малтлагаар Хань улсын эхэн үед холбогдох гурван хөлт хүрэл тогоо олдсон явдал нь эхлээд Жүнуо (朝那), дараа Уши (乌氏) гэж солигдсоныг тодорхой харуулна³⁹. Гүчен сянд мөн Баруун Хань улсын хүрэл, алтадмал, мөнгө, хүрэл хонь олдсон ба ойр орчимд нь Хань улсын үеийн булшнууд бий²¹. Иймээс Гүчен сянгийн Гүченгийн олдворууд бол Хань улсын Уши сянний байршлыг илэрхийлнэ.

³⁸ 罗丰:《固原青铜文化初论》,《考古》1990年8期。

³⁹ 韩孔乐、武殿卿:《宁夏固原发现汉初铜鼎》,《文物》1982年12期。

“Түүхийн тэмдэглэлийн” цуглуулга тайлбарын “Куо-ди ойллого (括地志) - д” өгүүлсэн нь, Уши бол “Жоу (周) -гийн хуучин газар, хожим Жунд оров, Цинь Хуй ван (秦惠王) эзлээд Уши сянь болгов” хэмээжээ. Гююань (固原) газарт Баруун Жоугийн эхэн үеийн булш ба дагалдуулсан тэрэг нийтлэг олдсон⁴⁰, мөн Цинь улсын үеийн загвартай хүлс, гүц, сэрвээт жад, илд зэрэг зүйлс илэрдэг бөгөөд хүлсэн дээр “Сяньян” (咸阳) гэсэн ханз сийлсэн бий²⁴. “Куоди ойллогод” тэмдэглэсэн бүхэнтэй уялдуулан үзвэл Цинь улсын Хуйвэнь ван (秦惠文) -гийн үед (НТӨ 337-311 он) Цинь улс эзлэн авсныг тодорхой нотолж байна. “Түүхийн тэмдэглэлийн” “Хуожигийн намтар” (货殖列传) Уши угсааны Луо (倮) нэрт хүн Жунгийн вантай (戎王) худалдаа хийхдээ сайн бөгөөд “Морь, үхрийг хөндий дүүртэл өсгөдөг. Цинь Шихуанди (秦始皇帝) Луог удирдагчаар томилж, тэр үеэс түшмэлийг дэслэж, засаглалыг хүлээсэн” хэмээн тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд, Уши нар тухайн үед эдийн засаг нь үргэлжлэн хөгжиж байсан бөгөөд хожим ууссан байж болох юм.

D бүсийн умард хэсгийн олдворууд нь өмнөд хэсгийн эрт үед хамаарах Гююаньий Мэнюань сянгийн (孟塬乡) булш, Самэнгийн (撒门) оршуулгын газар, Шила тосгоны (石喇村) булшнууд дахь олдворуудтай соёлын хэв шинжээр маш төстэй. Харьцуулах бичгийн сурвалж үгүй тул үүнийг Ушигийн эхэн үед хамаарах олдворууд хэмээн түр таамаглая.

E бүс бол “Хүннүгийн шастирт” заасан “Ицүгийн жунгийн” (义渠) газар бөгөөд түүхчид өөрөөр үзэж байсангүй. Ицү болон Цинь улсын харилцааны талаар хамгийн эртний мэдээ бол “Түүхийн тэмдэглэлийн” “Зургаан улсын он дараалалд (六国年表)” “Лигун гүн (厉共公) -гийн 6-р онд (НТӨ 471 он) Ицү гарч ирэв” гэсэн мэдээ юм. Түүний дараа урт хугацааны турш харилцан биенээ довтолсоор Цинь улсын Жаосян ван (昭襄王) -гийн 35-р онд (НТӨ 272 он) Цинь улсад сөнөөгджээ. Учир иймээс, уг газраас илэрдэг Хавар, намрын улсын сүүл үеэс Байлдаант улсын үед хамаарах олдворууд бол Ицүгийнх гэдэг нь маргаангүй юм. Гэвч “Мозы - Оршуулах ёслол, доод” (墨子·节葬下) ба “Лиэзы – Танвэн” (列子·汤问) сурвалжуудад “Цинь улсын өрнөдөд Ицүгийн улс буй. Тэдний төрөл төрөгсөд нас нөгчихөд түлээ хурааж (Лиэзы-д 积 – хураах цуглуулах гэж бичсэн), түүнийг галд шатаадаг. Утаа дээшилж (Лиэзыд 熏则烟上 утаа униар дээшилж гэж бичсэн), эзэн хаан нөгчиж, дараа ачлалт хүү болог гэж ерөөнө” хэмээн тэмдэглэжээ (秦之西有义渠之国者, 其亲戚死, 聚柴薪 (列子作积) 而焚之. 熏上 (列子作熏则烟上), 谓之登遐, 然后成为孝子.). Одоогийн байдлаар E бүсэд харьцангуй сайн хадгалагдсан ганцхан булш олдсон бөгөөд (Нин сяний Юанжя тосгон - 宁县袁家村) уг булшнаас модон авсанд нүүрийг дээш харуулан тэнэгэр байдалтай оршуулсан бүрэн араг яс илэрсэн ч ямар нэгэн чандарласан шинж байхгүй. Илүү олон булш малтаж судалж байж энэ асуудал тодорхой болно. Энд тэмдэглэхэд, Жинь (晋) улсын үеийн Жан-жан-ий (张湛) “Лиэзыд” хийсэн тайлбарт “Ицү” гэдгийг “Икан” (仪康) гэж бичсэн бол харин хуучин “Мозыд” “Ицү” гэдгийг “Ибин” (仪秉) гэж бичсэн ба Чин улсын үеийн Биюань (毕沅) “Лиэзы” ба “Тайпин гуанжи” (太平广记) бүтээлүүдэд эдгээрийг “Ицү (义渠)” болгон сольжээ. “Сюньзы, Их зам мөр” (荀子·大略) бүтээлд “Ди, Цянгийн бүдүүлгүүд (氏羌之虜) зүдрэхийг үл тоох атал эс шатаах

⁴⁰ 固原县文物工作站: 《宁夏固原县西周墓清理简报》, 《考古》1983年11期.

вий хэмээн зовно” гэжээ. “Лу овогтын хавар намрын тэмдэглэл, Ишан (吕氏春秋·义赏)”-д бичихдээ, “Ди, Цян нар, тэдний бүдүүлгүүд, ядрахаа үл хайхрах ч үхэхдээ эс шатаагдахаас зовно” гэжээ. Эдгээр нь чандарлах явдал бол ямар нэгэн газар оронтой хамааралгүйгээр Ди, Цянгийн уламжлал байж, Зүүн Жоугийн үед “Баруун Жун (西戎) -гийн” нэгэнд хамаарч байсан ба Ицү нь “Ди, Цян” мөн эсэх нь нэн эргэлзээтэй байна. Иймээс, цаашдын малтлага судалгаагаар л Ицү нар чандарлах уламжлалтай байсан эсэхийг хариулж чадна. Гэвч, чандарладаггүй учраас Ицү бус гэж хэлж бас болохгүй билээ.

Уши ба Ицүг эрт үед Баруун жун хэмээн нэрлэсэн ба Цинь улс нь үндсэндээ Баруун жунгаас улбаатай учраас “Баруун жунд Сичуй (西垂) -г хамгаалж” (“Түүхийн тэмдэглэл, Цинь улсын цадиг”), хожим Жоугийн соёлыг аван хүчжээд “Баруун Жунг ноёрхов” (“Зуочуань (左传), Вэньгүн (文公) -гийн 3-р он”) гэх зэргээр бичигдэж үлджээ. Зүүн Жоу улсын турш Цинь улс үргэлжид Баруун жунтай өргөн харилцаатай байж, Цинь улсын Жаосян (昭襄) ван “Цэрэг байгуулж Ицүг довтлон сөнөөж, Лунси (陇西), Бэйди (北地), Шан (上) мужуудыг (郡) авч, Ху (胡) -г эсэргүүцэхээр Цагаан хэрмийг байгуулсан” ба энэ үеэс Цинь улс Ху нартай жинхэнэ ёсоор нүүр тулан учирчээ. Уши ба Ицү нар нь мэдээж Ху биш ба иймээс тэднийг язгуурын Хүннүгийн уг эх гэж үзэж болохгүй.

Энд онцлон дэвшүүлэх ёстой зүйл бол, “Түүхийн тэмдэглэл, Жан Игийн намтар (张仪传)”-т НТӨ 318 онд зүүн таван улсаас Цинь улсад хийсэн довтолгоонд Ицүгийн удирдагч оролцсон тухай маш тодорхой бичиж үлдээсэн (“Байлдаант улсын бодлого”, Цинь улсын бодлого, Дэд, Ицү удирдагч Вэй (战国策·秦策二·义渠君之魏)” бүлэгт адил бичигдсэн) боловч мөн “Цинь улсын тэмдэглэлд” “Хань, Жао, Вэй, Янь, Ци (韩、赵、魏、燕、齐) Хүннүтэй хамтран Цинь улсыг довтлов” гэж бичжээ. Үүнийг дараах байдлаар ойлгож болно: Сыма Цянь Ицүг “Хүннүгийн шастирт” оруулан бичсэн юм бол, үнэндээ Ицүг Хүннү гэж нэрлэхэд болохгүй зүйл үгүй мэт. Гэхдээ, зөвхөн үүнд үндэслэн Ицү бол Хүннү юм гэж үзэх нь Мэнзийн “Номонд сохроор итгэснээс огт номгүй байсан нь дээр” гэж өгүүлсэнтэй адил юм.

Сурвалжийн тодорхой мэдээ баримт хомс учраас В, С, F бүсийн соёлын дурсгалуудын угсаа хамаарлыг тодорхойлоход хүндрэлтэй юм. “Байлдаант улсын бодлого” сурвалжийн “Жао улсын бодлого, Дэд, Улин ван өдөр хооронд амьдрахуй” (武灵王平昼间居) бүлэгт Жао улсын Улин ван (武灵王) хувцас сольж, морьт харваанд сурсан хэрэг явдлыг (НТӨ 307 он) тэмдэглэхийн хамт “Сян эзэн (Жао Сян (赵襄) -ыг хэлжээ) Жунтай хамтран олон Хуг хөөв” хэмээсэн ба эндээс бид Байлдаант улсын эхэнд Жао улс нэгэнт Ху нартай шууд харилцдаг, гэхдээ тэр нь ганц төрлийн Ху бус, харин олон төрлийн Ху байсныг харж болно. НТӨ 307 онд хамаарах тодорхой мэдээллээр “Дорнодод Янь улс (燕) ба Дунхутай хиллэнэ. Өрнөдөд Лоуфань (楼烦), Цинь, Хань (韩) улсуудтай хиллэнэ”, “Хувцсыг шинэчилж, морьт харваанд сурч, Гурван Ху (参胡), Лоуфань (楼烦), Цинь, Хань (韩) улсуудтай залгах хилээ сэргийлэв” хэмээжээ. “Түүхийн тэмдэглэлийн Жао удмын намтар (赵世家)” бүлэгт үг үсэг ялгаатай ч ижил мэдээ буй нь “Умардад Янь (燕), дорнодод Ху (胡), өрнөдөд Лоуфань, Линьху (林胡), Цинь (秦), Хань (韩) -тай хиллэв”, “Хувцас шинэчилж, морьт харваа сураад, Янь (燕), Гурван Ху (三胡), Цинь, Хань (韩) -тай залгах хилээ сэргийлэв” гэжээ.

“Олон Ху (诸胡)” нь энд “Дунху (东胡)”, “Линьху (林胡)”, “Гурван Ху (三胡)” болсон ба “Гурван Ху” гэж чухам аль төрлийн Хуг хэлж буй нь мэдэгдэхгүй байна. Харин, “Байлдаант улсын бодлогод” Гурван Ху ба Лоуфань хоёрыг тус тусад нь нэрлэснээс үндэслэн Лоуфань бол Ху биш хэмээн тогтоож болно. Хэрэв тийм биш бол яагаад “Дөрвөн Ху” гэж бичээгүй билээ? Үүнээс гадна “Түүхийн тэмдэглэлийн Ляньпо (廉颇), Линь Сянру (蔣相如) -гийн шастирт” Жао улсын Даосян (悼襄) вангийн анхдугаар оны өмнөхөн (НТӨ 245 он) Лиму (李牧) дайнд их амжилт олж, Дунху, Линьху хөөсөн тухай бичихдээ Чаньлань (襜褕) хэмээн хамт тэмдэглэсэн ба энэ Ху мөн биш нь тодорхойгүй юм.

Байлдаант улсын сүүл үед тодорхой нэр гарч буй угсаатны бүлгүүдийн нутаглаж байсан газрыг тодорхой тогтоох боломжгүй. Линьху ба Лоуфаний нутгийг зөвхөн “Байлдаант улсын бодлого” дотор гэхэд адилгүй тэмдэглэсэн бий. “Жао улсын бодлого, дэд” бүлэгт Жаогийн өрнөдөд, “Янь улсын бодлого, Тэргүүн (燕策一)” бүлгийн “Сүцинь дипломатч (苏秦将为从)” хэсэгт Янь улсын умардад хэмээн тус тус тэмдэглэсэн. Сяма Цянь “Түүхийн тэмдэглэлийн Жао удмын намтар” болон “Сү-циний шастирт” Сүциний өгүүлж буйг тэмдэглэснээр бол Линьху, Лоуфань нар Янь улсын умардад байсан цаг үеийг НТӨ 334 он хэмээн тооцож болно. Линьху ба Лоуфань нар НТӨ 334-307 оны үед дорно зүгээс өрнө зүгт нүүсэн байх боломжтой юу? Хэрэв “Янь улсын бодлогод” итгэхгүй бол Линьху ба Лоуфань нарыг ямагт Жао улсын өрнөдөд байсан гэж үзэхэд хүрэх ба яг хаана байсныг хэлэхэд амаргүй болно. “Жао удмын намтар” Жао улсын Ули вангийн 20-р онд (НТӨ 306 он) “Өрнөдөд Хугийн газар аялж, Южун (榆中) хүрэв. Линьхугийн ван морь өргөв” гэжээ. Гэвч Южун хаана байгаа талаар нэгдсэн ойлголт алга. “Хятадын эрт, эдүгээгийн газрын нэрийн толь бичиг (中国古今地名大辞典)”-т Тан (唐) улсын үеийн Жан Шоужие (张守节) -гийн “Түүхийн магад тэмдэглэлийг” (史记正义) үндэслэн “Ордосын Шар мөрний умард эргийн газар”, “Цьюань” бичигт (辞源) Сүнгийн төгсгөл, Юаний эхэн үеийн хүн Ху Саншэнгийн (胡三省) “Төрд туслах нэвтэрхий тольд суралцах тайлбарыг” (资治通鉴育注) баримтлан “Зүүнгар хошуу” (准格尔旗) хэмээжээ. “Жао удмын намтар” бичихдээ, Жао улсын Хуй И (惠义) вангийн 2-р онд (НТӨ 297 он) “Эзэн эцэг шинэ газарт аялж, Дай улсыг өрнөдөд шахаж, Сыхөд (西河) Лоуфаньтай учирч, цэргээ илгээв” хэмээсэн. “Сыхө” гэж аль голыг заасан нь тодорхойгүй. Энэ үгээр Түрүү Цинь улс, Хань улсын үеийн сурвалжуудад Шар мөрний өмнөд урсгалын хэсгийг заах нь бий, мөн Шар мөрний тухайн хэсгийн эрэг дагуух бүс нутгийг бас илэрхийлж болно. Иймээс, Лоуфань нь Хөдун (河东) байсан гэж үзэж болох ба Хань улсын үеийн Лоуфань сянь Хөдунд байсан гэж мөн үзэж болох байна. Лоуфань Хөсид (河西) байсан гэх үзэлд дэмжлэг болохуйц мэдээ бий нь Хань улсын Вэйцин (卫青) “Толын өмнөд газрыг эзлэхээр төлөвлөж... Байян, Лоуфаний ванг зорив” (Түүхийн тэмдэглэл, Вэй жанжин эрэлхэг морин цэргийн намтар) хэмээсэн мэдээ юм. Шар мөрний энэ хэсгийн хоёр эрэг дагуух газрыг Лоуфаний газар гэж үзэхэд болохгүй зүйлгүй. Мөн түүнчлэн НТӨ 245 оноос багахан хугацааны өмнөх үед холбогдуулан сурвалжуудад нэр дурьдагддаг “Чаньлань” (襜褕) хаана байсан талаар “Түүхийн тэмдэглэлд” мөн мэдээ байхгүй. “Түүхийн тэмдэглэлийн цуглуулга тайлбарт” Рүчунь (如淳 - Гурван улсын үеийн Чэнь мужийн туслагч түшмэл – орч.) “Дай улсын умардад” хэмээн өгүүлсэн нь хоосон төсөөллөөс цаашгүй юм.

Бичгийн сурвалжийн мэдээ зөвхөн эдгээрээр хязгаарлагдах бөгөөд бодитой угсаатны нэрс бүгд Байлдаант улсын дараах үед хамаарах тул одоо илрээд буй Хавар намрын улсын сүүл үед хамаарах олдворуудтай тулган харьцуулж үзэх хэрэгтэй. Харьцангуй өргөн хүрээнд, тасралтгүй үргэлжлэх археологийн судалгааны үр дүнд л тухайн үеийн угсаатны бүлгүүдийн бодит нөхцөл байдал тодорхой болж, дээр дурьдсан асуудалд илүү бодитой тайлбар хийх боломжтой болохсон билээ.

Төгсгөлд нь Хүннүгийн тухай ярих хэрэгтэй. Язгуурын Хүннүгийн уг эхийн тухай хамгийн эртний бичгийн мэдээ “Түүхийн тэмдэглэлийн Лянь По, Линь Сяну нарын намтарт (史记·廉颇蔺相如列传)” гарах бөгөөд үүнд НТӨ 245 оноос багахан хугацааны өмнө Лиму (李牧 - Жао улсын жанжин – орч.) “Дай, Яньмэньд (雁门) сууж, Хүннүг сэргийлэв”, тийнхүү Лиму “Хүннүг ихээр ялж, арав илүү түмэн адуу алав (олзлов – орч.), түүний хойно Хүннү арав гаруй жил ойргон ирж зүрхэлсэнгүй” гэжээ. Энэ цаг үед Жао улс хил дээрээ “Дай газраас Иньшань уул (阴山), Гаоцюэ (高阙) хүртэл урт хэрмийг байгуулж хамгаалав” (“Хүннүгийн шастир”). Энэ хэсгийн цагаан хэрэм Жао улсын Улин (武灵) ван умардад Линьху ба Лоуфаньийг цохисны дараа байгуулагдсан бөгөөд ойролцоогоор НТӨ 3-р зууны эхэнд хамаарна. Жао улсын цагаан хэрмийн баруун биеийг нэгэнт судлан тогтоосон нь Линьхэ сяний (临河县) дорно умардад байх Лянланшань уулын амнаас (两狼山口 - Жао улсын үеийн Гаоцюэ) Иньшань нурууг хярлан дорно хэсгийн Дацин уулын (大青山) өмнөд бэл, Жуозы сянь (卓资县) хүрээд умард зүгт үргэлжилдэг⁴¹. “Уул усны судар (山海经)” сурвалжийн “Ертөнцийн өрнөд этгээдийн судар (海内西经)” бүлэгт “Яньмэнь уул (雁门山), Яньчүгийн 雁出 хооронд Гаоцюэ (高柳) -гийн умардад буй. Гаоцюэ нь Дайгийн умардад буй” хэмээжээ. Хань улсын үеэс Умардын төрүүдийн үе хүртэл байсан Гаоцюэ сянь нь өнөөгийн Шаньси (山西) мужийн Янгао сяний (阳高县) нутагт буй, эртний Яньмэнь уул нь өнөөгийн Янгао (阳高) ба Өвөр Монголын Шинхөгийн (兴和) хооронд үргэлжилсэн уулс юм. “Уул усны судар”-ын “Пяошүй (漂水)” зүйлд энэ талаар “Тэр уул үелэн давхарлаж тогтсон, үүлнээс өндөрт бүрэлзэн харагддаг, дорно зүгт алслан үргэлжилнэ” хэмээн тайлбарлажээ. Энэ уулнаас Яньмэньшүй (雁门水) эх авч, “Дорно өмнө зүгт Гаолю сяний (高柳县) эртний хотын хойгуур урсдаг” ба энэ нь өнөөгийн Хуньюанаас (浑源) эх авч, Наньян голд (南洋河) цутгадаг гол юм. Энэ уул эртний Дай хөндийн баруун хойгуур хашиж оршино. Лиму жанжин Дай, Яньмэнь газарт Хүннүгээс сэргийлэн сууж байсан учир язгуурын Хүннүгийн үндсэн орд нь Жао улсын цагаан хэрмийн дорнод биеийн умард руу байсан гэж таамаглана. Энэ нь “Хүннүгийн шастирт” бичсэн Хань улсын эхэн үед “Шаньюйн орд нь Дай, Юньжунгийн (云中) харалдаа” хэмээсэнтэй тохирно.

Хэдийгээр Байлдаант улсын сүүл үед язгуурын Хүннү Жао улсын цагаан хэрмийн умардад байсан боловч, Жао улсын цагаан хэрэм байгуулагдахаас өмнөх үеийн Хүннү энэ зурвас газрын өмнө талын газар нутагт нүүж очиж байгаагүй, эсвэл нутаглаж байгаагүй хэмээн үзэж болохгүй. Учир иймээс, Жао улсын цагаан хэрмийн өмнөд нутгаас олддог Хавар намрын улс ба Байлдаант улсын үеийн олдворуудыг язгуурын Хүннүгийн уг эхтэй огт хамаагүй гэж шууд хэлэх боломжгүй

⁴¹ 盖山林、陆思贤：《阴山南麓的赵长城》，见《中国长城遗址调查报告集》，文物出版社，1980年

ба харьцуулах тодорхой стандарт баримжаа хэрэг болно. Энэ бол Байлдаант улсын сүүл үед цагаан хэрмийн умардад байсан язгуурын Хүннү ямархуу биет шинж чанар бүхий соёлын онцлогтой байсныг тодорхойлох явдал юм. Иймээс, Жао улсын цагаан хэрмийн умард бүс нутаг дахь Байлдаант улсын сүүл үеийн олдворуудын хайгуул судалгааг шат ахиулж, Хүннүгийн говийн өмнөх вангийн ордны оньсогыг тайлах явдал бол Хятадын археологичдын өмнө тавигдаж буй түүхэн зорилт юм. Одоогоор хараахан харьцуулалт хийх хангалттай хэмжээний жиших зүйлс бүрдээгүй байгаа бөгөөд хэрэв зөвхөн 1-р зурагт үзүүлж буй шинж чанарыг угсаатны олон бүлгүүдийн дотор өргөн тархсан нийтлэг элемент гэж үндэслэн Жао улсын цагаан хэрмийн шугамын дотор буй олдворууд бол язгуур Хүннүгийн уг эхтэй холбогдоно гэж үзвэл энэ нь бүхэлдээ шинжлэх ухаанч бус санал болох юм.

4. Шууд бус таамаглал

Байлдаант улсын сүүл үед хамаарах язгуур Хүннүгийн жишиг болохуйц олдворууд олдох үеийг хүртэл, одоогоор үнэндээ бидний хийж чадах зүйл бол олдоод буй Хань улсын үеийн Хүннүгийн олдворуудад үндэслэн язгуур Хүннүгийн хэв загварыг таамаглах явдал билээ.

Хятадын нутаг дэвсгэрээс Хань улсын үеийн Хүннүд хамаарах олдвор гэдэг нь тогтоогдсон дараах жишээнүүд бий.

1. Циньхай (青海) мужийн Датунгийн (大通) Дээд Суньжяжайгийн (上孙家寨) хүннү булш⁴². Булшнаас гарсан тамганы “Хань улсын захиргаанд Хань Хүннү эргэн зохиров” гэсэн бичгээр уг булшийг Хүннүгийнх гэж тодорхойлсон ба булшны хэлбэр, олдворуудын хийц загварт үндэслэн Дорнод Хань улсын сүүл үед хамааруулна (НТ 2-р зууны 2-р хагасаас 3-р зууны эх). Харамсалтай нь тус булшны оршуулах ёс бүхэлдээ Хань улсынх учир язгуур Хүннүгийн соёлын онцлогийг илтгэж чадахгүй болжээ. Харин гурван ширхэг гавлын ясны хэв шинж нь “Умард Азийн монголжуу төрхтөнтэй харьцангуй ойр хамааралтай байна”³².

2. Нинся (宁夏) мужийн Тунсиний (同心) Даодуньзыгийн (倒墩子) оршуулгын газар⁴³. Хоёр зүйлийн үндэслэлээр Хүннүгийн оршуулгын газар гэж тогтоосон нь: ① Малтаж гаргасан ваар сав ба нэвт сийлбэртэй чимэглэлийн зүйлс, зэс цагариг зэрэг нь Монгол нутаг дахь Хань улсын үеийн Хүннү булшнуудтай адил. ② Малтаж гаргасан тавтын зоос (五铢) нь Манчэнгийн (满城) Хань улсын булштай (НТӨ 113-104 он) адил. Юаньшоу (元狩) -гийн 2-р онд (НТӨ 121 он) Цагаан хэрмийн гадна орших Шар мөрний өмнөд эрэгт ирж дагаар орсон таван түшмэг улсын Аньдин (安定) зэрэг таван мужийн Хүннү нарыг Тяньшүйд (天水) суулгажээ. Тунсинь бол Аньдин муж дахь Цагаан хэрмийн гадна орших голын өмнөд газар, Тяньшүй гэдэг нь түшмэг улсуудын оршиж байсан газар юм.

“Хань улсын судар, Уди хааны намтарт” бичсэнээр, Юаньшоугийн 2-р онд дагаар ирсэн Хүннү бол Хүннүгийн өрнөд хэсэгт байсан Хунье ван (昆邪王, 浑邪王) Сюгү ванг (休屠王) алаад олноо авч Хань улсыг дагасан хэсэг ба тэдний уг нутаг нь Хөси (河西) коридорын Увэй (武威), Жане (张掖) газар юм. Гэвч тэднийг Юэжиг эзэлсний дараа Хөси коридорыг эзлэн суусан Хүннү, эсхүл

⁴² 青海省文物管理处考古队:《青海大通上孙家寨的匈奴墓》.《文物》1979年4期,

⁴³ 宁夏文物考古研究所等:《宁夏同心倒墩子匈奴墓地》,《考古学报》1988年3期.

язгуурын Хүннү бус байгаад Хүннүгийн холбоонд нэгдэн орсон алин болохыг тодорхойлох мэдээ сурвалжуудад байхгүй. Тэдний оршуулгын зан үйл нь нэн онцгой. Оршуулгын тогтолцоонд нь илэрхий ялгаатай хоёр хэлбэр буй нь, 1-рт, малын толгой шийр дагалдуулдаггүй, босоо нүхэн булш (竖穴墓), 2-рт, нэг нярайн булшийг эс тооцвол бүгдэд нь малын толгой шийр дагалдуулсан, нэг тал руу ухсан нүхтэй хөмөг булш. Булшинд дагалдуулсан эд зүйлийн тухайд тус хоёр хэлбэрийн хооронд тооны хувьд төдийлөн ялгаа байхгүй. Харин хөмөг булшнаас хоёр тохиолдолд алтан ээмэг илэрсэн бол босоо нүхтэй M18 булшнаас хамгийн олон тоотой зоос гарчээ. Үүнээс үзэхэд, оршуулгын ялгаатай хэлбэрийг нийгмийн ялгаралтай холбож үзэхэд хэцүү бөгөөд Маоцингоугийн булштай адилаар энэ бол нэг бүлэг хүмүүсийн дотор хоёр ялгаатай уламжлалт зан үйл оршин байсны тусгал гэж үзэх хэрэгтэй. Харамсалтай нь гавлын ясыг тодорхойлсон мэдээлэл олдоогүй учир хэв шинж нь мэдэгдэхгүй байна. Эдгээр булшнуудаас ямар нэг зэвсэг гараагүй явдал (нум сум хүртэл илрээгүй) онцгой анхаарал татна.

3. Өвөр Монголын Зүүнгар хошууны Сигоу (西沟) дэнжийн оршуулгын газар⁴⁴. Энэ оршуулгын олдворууд Монгол Улс дахь Хань улсын үеийн Хүннүгийн булшныхтай адил учир (ёроолдоо нүхтэй ваар, долгион хээтэй вааран суулга, амьтны загварт урлаг бүхий эдлэл зэрэг) Хүннүгийн булш гэж үздэг. Эндээс хятад загварын урт ханцуй бүхий бүжигчний чулуун баримал гарсан нь Өрнөд Хань улсын эхэн үед хамаарах тул Хүннүд дагаар ороод байсан Лоуфань, Байян вангийн овог аймгийнхны үлдээсэн дурсгал гэж үзэж болно. “Хүннүгийн шастирт” тодорхой тэмдэглэсэнээр, Чу, Хань улсын дайны үеэр Хүннү улс “Өмнөдөд Лоуфань, Байян, Хөнань ванг дагуулсан” ба “Түүхийн тэмдэглэл, Люжин (刘敬) ба Шүсуньтун (叔孙通) нарын намтарт” мөн НТӨ 198 онд “Люжин Хүннүгээс ирэв, Хүннүгийн Хөнань, Байян, Лоуфань ван Чананийг (长安) зорьж 700 газар ойртов, хөнгөн морин цэрэг нэг өдөр, нэг шөнө яваад Циньжун (秦中) хүрнэ хэмээв” гэж тэмдэглэжээ. НТӨ 127 оныг хүртэл Вэйцин (卫青) “Хугийн Лоуфань, Байян ванг голын өмнө (河南) цохиж, Хугийн хэдэн мянган толгойлогч, нэг сая илүү үхэр хонийг олзлов. Ингэж Хань улс голын өмнөд газрыг бүрэн эзлэв”. Ная орчим жилийн хугацаан дотор Шар мөрний өмнөд эргийн Бор тохойд зөвхөн “Лоуфань, Байян ван” буюу “Байян, Лоуфань ван” л байв (“Вэй жанжин эрэлхэг морин цэргийн намтар”). Тэд цохигдон зугатсаны дараа Хань улс голын өмнөд бүх нутгийг эзлэн авч, Шуофан мужийг (朔方郡) байгуулсан. Иймээс НТӨ 3-р зууны төгсгөлөөс НТӨ 127 он хүртэлх энэ цаг үеийн доторх Бор тохой дотроос олдох олдворууд “Лоуфань, Байян вангийн” аймгаас өөр ямар нэг аймаг байх үндэсгүй. Энэ аймаг бол язгуурын Хүннү бус ба язгуурын Хүннүтэй адилгүй өөрийн гэсэн бие даасан онцлог ялгаатай байж болох юм.

Судалгааны тайланд өгүүлснээр, M6 ба M9 булшнаас хонь, адууны бүтэн яс гарсан ба үүний дотроос M9 булшинд хонины хоёр бүтэн яс ба хонины нэг толгой дагалдуулсан нь “Амьтан хойлоглох зан үйл өргөн дэлгэрсэн байсныг тодорхой харуулна”. Гэвч, M9 булшнаас гарсан ваарны хэлбэр хийц ба хүрэл бөгжнөөс үзэхэд энэ булш нь Умардынхны төрийн 北朝 үеийн Сяньби булш байна⁴⁵ (6-р зураг). Мөн

⁴⁴ 伊克昭盟文物站等：《西沟畔汉代匈奴墓地调查记》，《内蒙古文物考古》创刊号，1981年。

⁴⁵ 包头市文物处：《包头固阳县发现北魏基群》《考古》1987年1期；内蒙古文物工作队编：《内蒙古文物资料选辑》，内蒙人民出版社，1962年；内蒙古文物工作队：《内蒙呼和浩特美岱村北魏墓》，《考古》1962年2期；

түүнчлэн, ямар нэгэн дагалдуулсан эд зүйлийн тухай мэдээлэл байхгүй учир М6 булшийг Өрнөд Хань улсын эхэн үед холбон үзэх боломжгүй байна.

Малгайн гоёмсог алтан чимэг болон бүсний алтан бүрмэл чимэг бүхий М4 болон түүнтэй адил булшнуудад малын яс дагалдуулаагүй, хүрэл зэвийг эс тооцвол ямар нэг зэвсэг бас дагалдуулаагүй (бүхэл оршуулгын газрын хэмжээнд өөр ямар нэг зэвсэг илрээгүй) явдал нь Өрнөд Хань улсын эхэн үеийн оршуулгын төлөв байдлыг илэрхийлнэ.

4. Өвөр Монголын Дуншэнгийн (东胜) Бүдонгоу (补洞沟) дахь оршуулгын газраас⁴⁶ Монгол Улс дахь Хань улсын үеийн Хүннүгийн булшнаас гарсантай адил шавар ваар ба төмөр эдлэл гарсан тул үүнийг Хүннүгийн оршуулга гэж үздэг. Уг булшнаас эвдэрхий хүрэл толины тал хэсэг гарсан нь Монгол Улс, Өвөр Байгалийн Хүннү булшныхтай зан үйлээр ижил байна. Хэрэв Монголын ба Зөвлөлтийн археологичдын нүдээр харвал энэ бол хангалттай хэмжээний “Хүннү үнэртэй” булш юм. Булшнаас TLV толь (规矩镜, 博局镜) гарсан бөгөөд иймээс Өрнөд Хань улсын сүүл үеэс Дорнод Хань улсын эхэн үеийн хоорондох цаг хугацаанд хамаарна. “Хожуу Хань улсын бичиг, Өмнөд хүннүгийн түүхэнд” (后汉书·南匈奴传) тэмдэглэснээр, Дорнод Хань улсын эхэнд өмнөд ба умард Хүннү хуваагдаж, Жяньвугийн (建武) 26-р онд (НТ 50 он) Хань улс өмнөд Хүннүгийн шаньюйд туслан Уюань (五原) мужийн баруун этгээдийн бэхлэлтэд 80 ли газар олгон суулгасан ба Юньжун (云中) рүү нүүж, мөн Сихө (西河) мужийн Мэйжи (美稷) сяньд сууж байсан нь эдүгээгийн Зүүнгар хошуу орчим юм. Учир иймээс, Бүдонгоугийн оршуулгын газар нь Дорнод Хань улсын эхэн үе дэх өмнөд Хүннүгийн шаньюйн овгийнхны дурсгал ба Ноён уулын орчим дахь умард Хүннүгийн шаньюйн овгийнхны булштай нэгэн адил байх учиртай.

Бүдонгоугийн хүннү булш ба Монгол Улсын хүннү булш адуу, үхэр, хонины толгой ижилхэн дагалдуулсан боловч нэг ялгаатай зүйл байгаа нь Ноён уулын том, дунд, жижиг булшнуудын дотор нум, сумнаас өөр зэвсгийн зүйл дагалдуулдаггүй бол харин Бү-дон-гоу-гийн нэгэн булшинд Хань улсын загвартай нэг төмөр илд дагалдуулсан явдал юм. Энэ бол өмнөд Хүннү Хань улсад дагаснаас хойш уламжлалд нь өөрчлөлт гарсныг харуулна.

Ноён уулнаас Умард Азийн салбар төрхтний палеосибирь хэв шинжид хамаарах эрэгтэй, эмэгтэй хүний тус бүр нэг гавлын яс олдсон. Харин Бүдонгоугаас харьцуулалт хийх гавлын яс илрээгүй.

Бидэнд буй мэдээлэлд тулгуурлан эрт үеийн язгуурын Хүннүг тодорхойлоход хүндрэлтэй бөгөөд зөвхөн зарим таамаглалыг дэвшүүлж болох юм.

1. Энгийн нөхцөл байдалтай үед антропологийн хэв шинж нь соёлынхоос илүү удаан өөрчлөгддөг. Дээд Суньжяжай (上孙家) -гийн хүннү булш бол үүний тод жишээ мөн. Иймээс, Дээд Суньжяжайгийн гавлын ясанд хийсэн шинжилгээний дүн болон Ноён уулын гавлын ясны хэв шинжид үндэслэн бид эртний язгуурын Хүннү нар бол Умард Азийн салбар төрхтөнд хамаарч байжээ гэж үзэж болно.

2. Булшны олдвор, хэрэглэгдэхүүн дэх соёлын хэв шинжээс үзэхэд эд өлгийн зүйлстэй харьцуулвал оршуулгын зан үйл нь илүү тогтвортой уламжлагдаж байсан шинж илэрхий байна. Маоцингоу болон Даодуньзыгийн оршуулгын газрууд нь дагалдуулсан эд өлгийн зүйлсэд ялгаатай шинж байхгүй боловч адил

⁴⁶ 伊克昭盟文物工作站：《伊克昭盟补洞沟匈奴墓地》，《内蒙古文物考古》创刊号，1981年。

бус зан үйлийг хадгалж буй нь үүний тодорхой жишээ юм. Энэ үүднээс, Бүдунгоу ба Ноён уулын оршуулгын зан үйлээс үндэслэн эртний язгуурын Хүннү нар мөн адил морь, үхэр, хонины толгойг дагалдуулдаг, оршуулах нүхийг эгц доош ухдаг, мөн түүнчлэн нум, сумнаас өөр зэвсгийн зүйл дагалдуулдаггүй зан үйлтэй байжээ хэмээн таамаглаж байна. Сигоупань ба Даодуньзыгийн булшнууд нум сумнаас өөр зэвсэг дагалдуулаагүй буюу эсвэл огт зэвсэг дагалдуулаагүй байдал нь эдгээр угсаатны бүлэг дэх оршуулгын тогтсон уламжлалыг харуулж байж болно.

Дээрх шинжийг агуулсан угсаатны бүлэг Байлдаант улсын үед байсан уу? Гуо сяний Яозыгийн оршуулгын газар бол үүний бодит жишээ юм. Гэвч бид Гуо сяний Яозыд оршуулсан хүмүүсийг язгуурын хүннүгийн уг эх гэж огт үзэхгүй байна. Энэ бүлэг хүмүүс Байлдаант улсын эхэн үед Бор тохойд нэгэнт нутаглаж байсан бөгөөд гахай тэжээж байсан нь хагас суурин амьдралыг илтгэх ба тэднийг Байлдаант улсын сүүл үе дэх Жао улсын Цагаан хэрмийн умардад маш хөдөлгөөнтэй амьдарч байсан язгуурын Хүннүгийн уг эх гэж хэлэхэд хэцүү. Тэд “Байлдаант улсын бодлогод” нэр гардаг “Олон Хугийн” (诸胡) нэг байх тун боломжтой ба тэднээс Байлдаант улсын үед оршин байсан ч бидэнд хараахан мэдэгдээгүй байгаа язгуурын Хүннүгийн туссан сүүдрийг харж болно.

Тав. Дүгнэлт

1973 онд Тянь Гуаньжин (田广金), Ли Зуожи (李作智) нар элсэн шуурган дунд зориглон Таохунбала ба Гунсүхао (公苏壕) дахь булшийг илрүүлж малтсанаар манай улс дахь (БНХАУ дахь – орч.) Хүннүгийн түүхийн үеийн археологийн малтлага судалгааг эхлүүлсэн билээ.

Сыма Цяниас эхлээд ямагт түүхийн хомс материалын улмаас сурвалжуудад гардаг умардын бүх аймгуудыг Хүннүгийн өвөг дээдэс хэмээн үзэж иржээ. Археологийн нээлтүүд улам бүр нэмэгдэж буй өнөө үед бид Сыма Цяниас хол илүү алхам урагшлав.

1. Сурвалжид тэмдэглэгдсэн умардын бүх аймгууд (жишээлбэл Дай, Ицү, Уши) ба сурвалжид тодорхой тэмдэглэж үлдээгүй угсаатны бүлгүүд (жишээлбэл Маоцингоу, Яо сяний яозы зэрэг газарт буй дурсгалыг үлдээсэн угсаатнууд) бол антропологи ба соёлын хэв шинжээрээ өөр хоорондоо ялгаатай бөгөөд тэднийг хамтатган үзэх буюу эсвэл өөр угсаатны нэршлүүдийг хамаагүй адилтган үзэж болохгүй юм.

2. Олон угсаатны бүлэг оршин байсан нөхцөлд, аль угсаатан нь Хүннүг мандахаас өмнө мөхөж сөнөсөн буюу Хятадад ууссан, аль угсаатан нь үргэлжлэн оршиж, хөгжсөөр Хань улсын үеийн Хүннүгийн “тогоонд” жинхэнэ ёсоор багтан орсныг бодитоор ялгах хэрэгтэй. Хань улсын үеийн Хүннүгийн холбооны нутаг дэвсгэр дээр урьд өмнө оршин байсан ард түмэн бүрийг хялбархнаар Хүннүгийн өвөг дээдэс хэмээн тооцох ёсгүй.

3. Хэдийгээр Хүннүгийн холбоо байгуулагдсанаар соёлын ижилсэл эрчимжсэн боловч түүнд багтсан аймаг, угсаатнууд өөр өөрсдийн онцлогоо хадгалсаар байсан нь археологийн судалгаагаар харагдаж байна.

Эдгээр ойлголт бидэнд язгуурын Хүннүгийн угсаа гарлын асуудлыг Хань улсын үеийн бүх Хүннүгийн угсаа гарлын асуудлаас тусгайлан ялгаж, онцгой судалгаа хийх шаардлагатай болохыг ойлгуулж байна. Мөн түүнчлэн, археологийн судалгаагаар язгуурын Хүннүгийн угсаа гарал судлалыг шийдвэрлэх боломжтой гэж бид итгэж байна.

Мэдээж энэхүү язгуурын Хүннү нар өнөөгийн Хятадын хилийн гадна эрт үеийнхээ түүхийг туулж өнгөрөөсөн гэж бас үзэж болно. Ингэвэл энэ нь олон улсын шинжтэй судалгааны ажил болно. Гэвч сурвалжийн мэдээг шүүж үзвэл НТӨ 3-р зуунаас НТӨ 2-р зууны дунд үе хүртэлх хугацаанд язгуурын Хүннүгийн үйл ажиллагаа Өвөр Монголын хэсгийн умардад төвлөрч байна. Иймээс Хятадын археологичид үүнд олзуурхахын хамт үнэн хэрэгтээ илүү их үүрэг хүлээх ёстой.

Бид Сыма Цяниас нэг алхмаар урагшилсан, одоо бид том үсрэлт хийх ёстой.

(Орчуулсан Н.Алтантөгс)